



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дашинчилэн сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2023/26/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.open.audit.mn</p> <p>Булган аймаг 2023 он</p>	<p>Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ Утас: 7034-2580 Цахим хаяг: Erdeneb@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 7034-2716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Д.Анхбаяр Утас: 7034-2495 Цахим хаяг: Ankhubayard@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	15
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
4.5.1 Завсрын аудитын талаар.....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	17
5.1 Төлбөрийн акт.....	18
Төлбөрийн акт тогтоогдоогүй болно.....	18
5.2 Албан шаардлага.....	18
5.3 Зөвлөмж.....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
НӨУБ	Нутгийн өөрөө удирдах байгууллага
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНӨХХК	Орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХАБХШХ	Хүн амын богино хугацааны шилжих хөдөлгөөн
ХАА	Хөдөө аж ахуй

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2023.02.24 № 192

танай _____ ны № _____ Т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дашинчилэн сумын ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дашинчилэн сумын ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Аймгийн ИТХ-ын VII/12 дугаар хуралдааны тогтоолоор 25,470.7 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж бэлтгэсэн, сумын Засаг даргын 2022 оны А/29 дугаар захирамжийг үндэслэн сумын ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 85,185.0 мянган төгрөгийн зам гүүрийн байгууламж, 8,400.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмжийг орлогод авч тайлагнаснаас шалтгаалан тайлант хугацааны үр дүнд нөлөөлжээ.

Аудитын гол асуудал

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2-15.1.7 дахь заалтуудад заасан хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	140,898,835.00	187,189,374.00
33	АВЛАГА	4,480,000.00	400,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	400,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	4,480,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	136,418,835.00	168,438,124.00
351	Түүхий эд материал	18,804,709.00	18,804,709.00
35110	Тусгай зориулалттай материал	18,804,709.00	18,804,709.00
354	Хангамжийн материал	87,509,126.00	116,768,415.00
35410	Бичиг хэргийн материал	42,852,775.00	42,852,775.00
35420	Аж ахуйн материал	41,445,918.00	72,596,718.00
35440	Түлш, шатах тослох материал	3,210,433.00	1,318,922.00
35600	Мал амьтад	30,105,000.00	32,865,000.00
36	НӨӨЦИЙН БАРАА	-	18,351,250.00
36300	Тэжээлийн нөөц	-	18,351,250.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,079,528,713.98	1,053,463,594.07
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,079,528,713.98	1,053,463,594.07
392	Биет хөрөнгө	1,069,071,713.98	1,043,719,094.07
39201	Барилга, байгууламж, орон сууц	631,114,649.68	631,114,649.68
39202	Хуримтлагдсан элэгдэл	(314,845,508.13)	(328,572,483.81)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	363,364,800.00	325,294,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(232,512,762.31)	(233,282,371.87)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	114,238,542.15	142,831,092.15
39206	Хуримтлагдсан элэгдэл	(67,739,241.95)	(79,450,900.06)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	47,689,347.87	46,218,851.10
39208	Хуримтлагдсан элэгдэл	(22,831,702.13)	(27,373,589.32)
39209	Зам, гүүрийн байгууламж	376,468,603.00	450,185,998.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(355,363,456.32)	(412,735,393.92)
39214	Бусад үндсэн хөрөнгө	718,105,148.00	718,105,148.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(188,616,705.88)	(188,616,705.88)
393	Биет бус хөрөнгө	10,457,000.00	9,744,500.00
39301	Програм хангамж	6,555,500.00	3,050,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(4,530,500.00)	(1,737,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	8,432,000.00	8,432,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,220,427,548.98	1,240,652,968.07
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,220,427,548.98	1,240,652,968.07
51	Засгийн газрын хувь оролцоо	1,220,427,548.98	1,240,652,968.07
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	371,036,961.17	371,036,961.17

51101	Өмч: - төрийн	371,036,961.17	371,036,961.17
512	Хуримтлагдсан үр дүн	535,709,659.57	555,935,078.66
51210	Өмнөх үеийн үр дүн	605,088,784.56	535,709,659.57
51220	Тайлант үеийн үр дүн	(69,379,124.99)	20,225,419.09
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	313,680,928.24	313,680,928.24
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,220,427,548.98	1,240,652,968.07

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	603,456,268.00	655,582,250.77
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	89,239,668.00	219,261,862.00
120	Нийтлэг татварын бус орлого	89,239,668.00	219,261,862.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	89,239,668.00	219,261,862.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		4,458,047.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,587,200.00	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	85,652,468.00	214,803,815.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	514,216,600.00	436,320,388.77
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	116,774,000.00	30,261,840.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	116,774,000.00	30,261,840.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	397,442,600.00	406,058,548.77
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	397,442,600.00	406,058,548.77
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	645,339,304.07	566,512,981.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	645,339,304.07	566,512,981.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	613,394,510.73	563,845,868.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	222,886,534.00	226,124,007.00
210101	Үндсэн цалин	149,712,893.00	169,256,847.00
210102	Нэмэгдэл	44,417,707.00	35,622,532.00
210104	Урамшуулал		6,192,819.00
210105	Гэрээт ажлын хөлс	28,755,934.00	15,051,809.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,059,213.66	28,112,643.00
210201	Тэтгэврийн даатгал	20,166,916.96	19,250,394.51
210202	Тэтгэмжийн даатгал	2,237,398.97	2,261,727.36
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,779,559.88	1,813,454.19
210204	Ажилгүйдлийн даатгал	443,467.35	435,193.88
210205	Эрүүл мэндийн даатгал	4,431,870.50	4,351,873.06
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49,649,069.00	34,034,966.00
210301	Гэрэл, цахилгаан	5,354,782.00	4,406,616.00
210302	Түлш, халаалт	23,173,800.00	24,149,850.00
210303	Цэвэр, бохир ус	21,120,487.00	5,478,500.00

2104	Хангамж, бараа материалын зардал	28,848,528.00	33,417,621.00
210401	Бичиг хэрэг	2,341,090.00	2,650,900.00
210402	Тээвэр, шатахуун	20,584,134.00	22,899,681.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,745,804.00	3,542,590.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000.00	4,127,350.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	999,500.00	197,100.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	178,000.00	
2105	Нормативт зардал	1,679,800.00	909,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,679,800.00	909,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,065,110.00	40,201,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	65,000.00
210604	Урсгал засвар	6,065,110.00	40,136,600.00
2107	Томилолт, зочны зардал	1,498,000.00	4,780,000.00
210702	Дотоод албан томилолт	1,498,000.00	4,780,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,032,453.00	1,474,917.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		570,567.00
210803	Даатгалын үйлчилгээ	202,400.00	64,350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	400,000.00	398,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	260,000.00	242,000.00
210807	Газрын төлбөр	170,053.00	200,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	272,675,803.07	194,791,114.91
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	115,226,933.00	48,170,280.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,250,000.00	1,500,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	156,198,870.07	145,120,834.91
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,944,793.34	2,667,112.77
2132	Бусад урсгал шилжүүлэг	30,144,800.00	2,250,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	10,254,700.00	
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,110,100.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,780,000.00	2,250,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,799,993.34	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,799,993.34	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	417,112.77
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		417,112.77
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(41,883,036.07)	89,069,269.09
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	15,820,000.00	12,845,000.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	15,820,000.00	12,845,000.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	43,316,088.92	81,688,850.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	43,316,088.92	81,688,850.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(27,496,088.92)	(68,843,850.00)

5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(69,379,124.99)	20,225,419.09
---	--------------------------------	------------------------	----------------------

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	517,803,800.00	445,258,435.77
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,587,200.00	4,458,047.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,587,200.00	4,458,047.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,587,200.00	4,458,047.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		4,458,047.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,587,200.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	514,216,600.00	440,800,388.77
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	116,774,000.00	34,741,840.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	116,774,000.00	34,741,840.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	397,442,600.00	406,058,548.77
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	397,442,600.00	406,058,548.77
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	492,780,750.00	419,787,735.77
21	УРСГАЛ ЗАРДАЛ	492,780,750.00	419,787,735.77
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	459,535,956.66	418,870,623.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	222,886,534.00	225,091,607.00
210101	Үндсэн цалин	151,206,869.00	168,224,447.00
210102	Нэмэгдэл	45,357,246.00	35,891,859.00
210104	Урамшуулал		6,192,819.00
210105	Гэрээт ажлын хөлс	26,322,419.00	14,782,482.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,059,213.66	28,112,643.00
210201	Тэтгэврийн даатгал	20,166,916.96	19,250,394.51
210202	Тэтгэмжийн даатгал	2,237,398.97	2,261,727.36
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,779,559.88	1,813,454.19
210204	Ажилгүйдлийн даатгал	443,467.35	435,193.88
210205	Эрүүл мэндийн даатгал	4,431,870.50	4,351,873.06
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49,649,069.00	42,508,966.00
210301	Гэрэл, цахилгаан	5,354,782.00	4,406,616.00
210302	Түлш, халаалт	23,173,800.00	24,149,850.00
210303	Цэвэр, бохир ус	21,120,487.00	13,952,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,807,194.00	24,886,210.00
210401	Бичиг хэрэг	2,353,590.00	2,575,900.00
210402	Тээвэр, шатахуун	9,707,800.00	13,779,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,745,804.00	3,542,590.00

/Төгрөгөөр/

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000.00	4,496,620.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000,000.00	491,300.00
2105	Нормативт зардал	3,099,300.00	796,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,099,300.00	796,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,419,940.00	36,175,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	220,000.00	389,500.00
210604	Урсгал засвар	6,199,940.00	35,785,500.00
2107	Томилолт, зочны зардал	1,498,000.00	4,780,000.00
210702	Дотоод албан томилолт	1,498,000.00	4,780,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,032,453.00	1,474,917.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		570,567.00
210803	Даатгалын үйлчилгээ	202,400.00	64,350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	400,000.00	398,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	260,000.00	242,000.00
210807	Газрын төлбөр	170,053.00	200,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	128,084,253.00	55,044,480.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	126,934,253.00	53,544,480.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,150,000.00	1,500,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,244,793.34	917,112.77
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,964,800.00	500,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	10,254,700.00	
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,110,100.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,279,993.34	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,279,993.34	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	417,112.77
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		417,112.77
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	25,023,050.00	25,470,700.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	25,023,050.00	25,470,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	25,023,050.00	25,470,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	25,023,050.00	25,470,700.00
222001	Тоног төхөөрөмж	22,923,050.00	25,470,700.00
223001	Бусад хөрөнгө	2,100,000.00	
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(25,023,050.00)	(25,470,700.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	371,036,961.17	313,680,928.24	605,088,784.56	1,289,806,673.97
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	371,036,961.17	313,680,928.24	605,088,784.56	1,289,806,673.97
3	Тайлант үеийн үр дүн	-	-	(69,379,124.99)	(69,379,124.99)
4	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	371,036,961.17	313,680,928.24	535,709,659.57	1,220,427,548.98
5	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	371,036,961.17	313,680,928.24	535,709,659.57	1,220,427,548.98
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	371,036,961.17	313,680,928.24	535,709,659.57	1,220,427,548.98
7	Тайлант үеийн үр дүн			20,225,419.09	20,225,419.09
8	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	371,036,961.17	313,680,928.24	555,935,078.66	1,240,652,968.07

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	418,264,500.00	410,099,483.00	8,165,017.00	98.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	418,264,500.00	386,628,783.00	31,635,717.00	92.44
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	417,764,500.00	386,128,783.00	31,635,717.00	92.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	228,561,800.00	225,091,607.00	3,470,193.00	98.48
210101	Үндсэн цалин	172,872,200.00	168,224,447.00	4,647,753.00	97.31
210102	Нэмэгдэл	40,587,700.00	35,891,859.00	4,695,841.00	88.43
210105	Гэрээт ажлын хөлс	15,101,900.00	14,782,482.00	319,418.00	97.88
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,827,300.00	28,112,643.00	714,657.00	97.52
210201	Тэтгэврийн даатгал	19,339,300.00	19,250,394.51	88,905.49	99.54
210202	Тэтгэмжийн даатгал	2,392,900.00	2,261,727.36	131,172.64	94.52
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,914,400.00	1,813,454.19	100,945.81	94.73
210204	Ажилгүйдлийн даатгал	471,000.00	435,193.88	35,806.12	92.40
210205	Эрүүл мэндийн даатгал	4,709,700.00	4,351,873.06	357,826.94	92.40

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,681,800.00	28,788,966.00	1,892,834.00	93.83
210301	Гэрэл, цахилгаан	6,297,100.00	4,406,616.00	1,890,484.00	69.98
210302	Түлш, халаалт	24,234,700.00	24,149,850.00	84,850.00	99.65
210303	Цэвэр, бохир ус	150,000.00	232,500.00	-	155.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,902,800.00	24,886,210.00	16,590.00	99.93
210401	Бичиг хэрэг	2,578,500.00	2,575,900.00	2,600.00	99.90
210402	Тээвэр, шатахуун	13,779,800.00	13,779,800.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,544,500.00	3,542,590.00	1,910.00	99.95
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,500,000.00	4,496,620.00	3,380.00	99.92
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000.00	491,300.00	8,700.00	98.26
2105	Нормативт зардал	800,000.00	796,800.00	3,200.00	99.60
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	796,800.00	3,200.00	99.60
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	58,800,000.00	36,175,000.00	22,625,000.00	61.52
210601	Багаж, техник, хэрэгсэл	23,000,000.00	389,500.00	22,610,500.00	1.69
210604	Урсгал засвар	35,800,000.00	35,785,500.00	14,500.00	99.96
2107	Томилолт, зочны зардал	6,120,000.00	4,780,000.00	1,340,000.00	78.10
210702	Догоод албан томилолт	6,120,000.00	4,780,000.00	1,340,000.00	78.10
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,820,800.00	1,474,917.00	345,883.00	81.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	580,000.00	570,567.00	9,433.00	98.37
210803	Даатгалын үйлчилгээ	326,700.00	64,350.00	262,350.00	19.70
210804	Тээврийн хэрэгслийн татвар	450,100.00	398,000.00	52,100.00	88.42
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	264,000.00	242,000.00	22,000.00	91.67
210807	Газрын төлбөр	200,000.00	200,000.00	-	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	37,250,000.00	36,022,640.00	1,227,360.00	96.71
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	35,750,000.00	34,522,640.00	1,227,360.00	96.57
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,500,000.00	1,500,000.00	-	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	500,000.00	500,000.00	-	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	500,000.00	-	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	500,000.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	418,264,500.00	410,516,595.77	7,747,904.23	98.15
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	413,264,500.00	406,058,548.77	7,205,951.23	98.26
132001	Орон нутгийн төсвөөс	413,264,500.00	406,058,548.77	7,205,951.23	98.26
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	5,000,000.00	4,458,047.00	541,953.00	89.16
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,000,000.00	4,458,047.00	541,953.00	89.16
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	20	20	-	100.0
620001	Удирдах ажилтан	7	7	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	10	10	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	3	3	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	34,741,840.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	32,741,840.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	32,741,840.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,720,000.00
210303	Цэвэр, бохир ус	13,720,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,021,840.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,021,840.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,000,000.00
222001	Тоног төхөөрөмж	2,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	34,741,840.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	34,741,840.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	34,741,840.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дашинчилэн сумын Засаг даргын тамгын газар эрхэм зорилгоо “Ардчиллыг бэхжүүлэх, НӨУБ-ыг төлөвшүүлэх, сумын нийгэм эдийн засгийн тулгамдсан асуудлыг иргэдийн оролцоотой шийдвэрлэхэд тэдний идэвх санаачилга нөөц боломжийг дайчлах замаар орон нутгийн тогтвортой тэнцвэрт хөгжлийг хангах” гэж тодорхойлжээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаандаа Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай, шилэн дансны тухай, Татварын багц, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон түүнийг дагалдаж гарсан тогтоол, дүрэм журам, эрх бүхий албан тушаалтнуудын шийдвэрүүдийн хэрэгжилтийг ханган үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дашинчилэн сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дашинчилэн сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/424 дугаар захирамжаар баталсан бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. 2022 онд бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 100,379.1 мянган төгрөгөөр буюу 8.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	4,480.0	400.0	(4,080.0)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	136,418.8	186,789.4	50,370.6
Үндсэн хөрөнгө	1,079,528.7	1,053,463.5	(26,065.2)
Нийт хөрөнгө	1,220,427.5	1,240,652.9	20,225.4
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,220,427.5	1,240,652.9	20,225.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,220,427.5	1,240,652.9	20,225.4

Дээрх хүснэгтээс харахад тайлант онд материаллаг өөрчлөлт гарсан данс нь үндсэн хөрөнгө, үндсэн хөрөнгийн оролцоо данснууд өссөн байна.

Сумын ИТХ-ын VII/12 дугаар хуралдааны тогтоолоор 25,470.7 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж бэлтгэсэн, сумын Засаг даргын 2022 оны А/29 дугаар захирамжийг үндэслэн сумын ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 85,185.0 мянган төгрөгийн зам гүүрийн байгууламж, 8,400.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмжийг орлогод авч тайлагнаснаас шалтгаалан тайлант хугацааны үр дүн нэмэгдсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 517,283.9 мянга, өөрийн орлогоос 5,000.0 мянган төгрөг нийт 522,283.9 мянган төгрөгийг бүрдүүлэхээр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаар зардлыг 413,264.5 мянган төгрөгөөр, өөрийн орлогоос 5,000.0 мянган төгрөг нийт 418,264.5 мянган төгрөгөөр баталж, Тайлант онд аймгийн 2022 оны төсөв баталсан тогтоол өөрчлөх тухай 2022 оны 6 дугаар сарын 23-ны өдөр 10/16 дугаар хуралдаанаар 1 удаа төсөвт тодотгол хийсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр өөрийн орлого 5,000.0 мянга, орон нутгийн төсвөөс 413,264.5 мянган төгрөг нийт 418,264.5 мянган төгрөгийг бүрдүүлэхээр байна. Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 413,258.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, 4,470.0 мянган төгрөгийн өөрийн орлогыг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 410,099.3 мянган төгрөг буюу 98.0 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 8,165.2 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Арга хэмжээ				
Нийт дүн			418,264.5	410,099.3	8,165.2	98.0
1	70106	80101	305,644.9	297,556.5	8,088.4	97.4
2		80106	50,283.1	50,215.6	67.5	99.9
3		80112	22,336.5	22,336.4	0.1	100.0
4		80802	500.0	500.0	-	100.0

5		81102	30,000.0	29,994.2	5.8	100.0
6		82212	4,500.0	4,496.6	3.4	99.9
7		82801	5,000.0	5,000.0	-	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд 189,286.7 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт авч эдийн засгийн ангиллын дагуу зарцуулалтын эрх нээлгэн зарцуулсан байна. Нэмэлт орлогын эх үүсвэрийг хүснэгтээр харуулав.

/мянган төгрөг/

№	Эх үүсвэр	Мөнгөн дүн
1	Булган мээж ОНӨХХК-аас төрөөс хариуцах усны төлбөрт	13,720.0
2	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас цэвэр орчин цэмцгэр булган аяны хог хаягдлын цэвэрлэх зардалд	1,500.0
3	Аймгийн Засаг даргын тамгын газраас оготно устгалын зардалд	15,678.1
4	Статистикийн хэлтсээс ХАА-н мал тооллогын зардал, ХАБХШХ-ийг тандах судалгааны зардалд	3,843.7
Нийт дүн		34,741.8

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дашинчилэн сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Анхбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Дашинчилэн сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03/7 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвөөс 448,264.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 6,273.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 4,705.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2-15.1.7 дахь заалтуудад заасан хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

Хуулийн 15 дугаар зүйлд заасан хэмнэлтийн бусад арга хэмжээтэй холбоотой зардлуудыг санхүүжүүлээгүй байна. Хуулийн 20 дугаар зүйлийн тайлагнал, ил тод байдлын 20.5 -д заасан этгээд шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны тухай хуульд заасан нийт 152 мэдээлэл мэдээлэхээс хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан

мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант хугацаанд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон зөвлөмжийн хэрэгжилтийг 2022 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 03/33 дугаар албан тоотоор ирүүлсэн.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	5	3,035.0	5	3,035.0	5
Албан шаардлага	7	319,267.3	7	319,267.3	7
Зөвлөмж	2	-	2	-	2
Нийт дүн	14	322,302.3	14	322,302.3	14

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын гүйцэтгэх цаг хугацааны нөөц, цар хүрээ хязгаарлагдмал байсан учраас дараагийн санхүүгийн тайлангийн аудитаар бараа материал, үндсэн хөрөнгийн үлдэгдэлд бүрэн тооллогын горим сорил хэрэгжүүлэн, өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны тайлан, 2022 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын тайланд дурдсан зүйлсийг шийдвэрлэсэн байдал зэргийг тусгайлан авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 14,915.0 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 14,915.0 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Анхан шатны баримтын иж бүрдэл дутуу монгол шуудан болон иргэн, ААН-тэй холбоотой нийт 1,910.4 мянган төгрөгийн зургаан ажил гүйлгээний и-баримтгүй гүйлгээ хийгдсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 “Аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг мөрдөх анхан шатны баримтын загвар, бүрдүүлэх аргачлалыг санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан Өмчийн бүх хэлбэрийн аж ахуй нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх зааврын 6.5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QRкодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасантай нийцээгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бэлтгэн нийлүүлэгч талын борлуулалтын орлогыг баталгаажуулан и-баримтыг тухай бүр шаардаж, төлбөрийн баримтыг авч хэвших.

2. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Засаг даргын нөөц хөрөнгийг пос төхөөрөмж авахад 897.6 мянга, теннисний ширээ авахад 1200.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1, 3.1.2 дахь заалтыг хэрэгжүүлээгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж хэвших.

3. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Шатахуун зарцуулахдаа анхан шатны баримтын бүрдэлгүй, 7 сараас хойш, шаардах хуудасгүй зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” заалтыг хэрэгжүүлээгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг санхүүгийн тайланд тусгахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны		
Анхан шатны баримтын иж бүрдэл дугуу монгол шуудан болон иргэн, ААН-тэй холбоотой нийт 1,910.4 мянган төгрөгийн зургаан ажил гүйлгээний и-баримтгүй гүйлгээ хийгдсэн.	1	1,910.4	-	-	-	-	1	1,910.4	-	-	-	-
Засаг даргын нөөц хөрөнгийг пос төхөөрөмж авахад 897.6 мянга, теннисний ширээ авахад 1200.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан.	1	2,097.6	-	-	-	-	1	2,097.6	-	-	-	-
Шатахуун зарцуулахдаа анхан шатны баримтын бүрдэлгүй, 7 сараас хойш, шаардах хуудасгүй зарцуулсан.	1	10,907.0	-	-	-	-	1	10,907.0	-	-	-	-
Дүн	3	14,915.0	-	-	-	-	3	14,915.0	-	-	-	-